## ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

| № | ЗОРИЛГО | ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ, ХЭРЭГЖИЛТ | ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; | -Баримтжуулсан байх<br>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)<br>-Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх. | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн хэвлэмэл болон хөдөлгөөнт төхөөрөмж дээр ажиллах бүх мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд шуурхай, түгээж, цахим хуудасны нүүр хэсэгт байгууллагын холбоос, авлигаас урьдчилан сэргийлэх санал хүсэлтийн форм, богино хэмжээний шторкуудыг байршуулсан байна.<br>Байгууллагын цахим хуудасны www.uda.ub.gov.mn Хууль эрх зүйн буланд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийг байршуулан олон нийтэд нээлттэй сурталчлан ажиллав.<br>Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системийн холбоос, болон “Авлигын эсрэг хамтдаа” таныг сонсож байна буланг тогтмол ажиллуулж байна.<br>Цахим хуудасны нийт хандалтын тоо 20473.<br>Авлигтай тэмцэх газраас гаргасан Соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Авлигыг мэдээл 110" - “Зөв зөвд Шударга зөв наалтыг байгууллагын 11 албан тасалгааны өрөөний үүдэнд байршуулсан.<br>Нийгмийн сүлжээгээр бүх албан хаагчид бусадтай мэдээллийг хуваалцаж байна.<br>- https://fb.watch/iKlhdytO53/<br>- 230216 avligiin gemt hereg 2-4 ok.mp4<br>- https://iaac.mn/post/104859<br>- https://www.youtube.com/watch?v=izAE3ilHnyQ&t=1s<br>- ATG_HOM_SHTORK_OK3.mp4 | 100 |
| | | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт | -2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; | Авлигатай тэмцэх газраас 2022 онд Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан зохион байгуулсан “АВЛИГЫН ЭСРЭГ ГЭРЭЛ ЗУРГИЙН ҮЗЭСГЭЛЭН"-д шалгарсан 10 бүтээлийг иргэд, олон нийтэд 14 хоногийн хугацаанд танилцуулахаар В1 давхарт 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 1 сарын хугацаатай байршуулж, хүн, хуулийн этгээдэд ил тод нээлттэй танилцуулах арга хэмжээг авч ажиллав. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | тохируулан зохион байгуулах; | -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. | Байгууллагын нийт албан хаагчдад дээрх бүтээлүүдийг танилцуулж, дүн шинжилгээ хийн, авлигаас ангид байх чиглэлээр тодорхой санал санаачилгатай ажиллахыг уриалан ажиллав.<br>www.facebook.com/groups/1873355006275950<br><br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 384 жилийн ойг угтан Монгол Улсын Засгийн газраас Авлигатай тэмцэх жилийн хүрээнд хэрэгжүүлж буй “5Ш ажиллагаа”, Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг дэмжих, албан хаагчдын ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг, харилцаа, хандлагыг нэмэгдүүлэх, ур чадварыг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх байгууллагын үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэх зорилго бүхий “МЭДЬЕ, НЭГДЬЕ” аянд Хот байгуулалт, хөгжлийн газрын хамт олон нэгдэж, аяны удирдамжаар баталсан санал санаачилга, мэдээ мэдээллийг түгээж ажиллав.<br><br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3613986095546157<br>www.youtube.com/watch?v=9yyGZAQsvRc<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3604272443184189/<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3604319146512852/<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3603511389926961/<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3603499923261441/<br><br>Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын талаарх онолын болон практик судалгаа, дүн шинжилгээг хөгжүүлэх, үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн "Шударга ёс" онол арга зүйн 2023 оны сэтгүүлийг түгээн сурталчилан ажиллав.<br><br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3550320638579370<br>https://erp.ulaanbaatar.mn/#/home/64ba2f70ffc2e4165ff9be42<br><br>Авлигын эсрэг олон улсын өдрийн тохиолдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан “Олон улсын авлигын эсрэг өдөр”, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын оролцоо” сэдэвт зөвлөгөөнд газрын удирдах албан тушаалтан, ахлах мэргэжилтэн нийт 23 албан хаагч оролцов. Зөвлөгөөний | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | танилцуулга, мэдээллийг нийт албан хаагчдад танилцуулав. https://www.facebook.com/groups/1873355006275950 Авлигатай тэмцэх газрын 2023 оны "Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай" 10 дугаар сарын 31-ний өдрийн 06/17495 дугаар албан бичгээр ирүүлсэн Мөрдөгчийн 131 дүгээр мэдэгдэлтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргаас 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 01/7403 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийг нийт албан хаагчдад танилцуулж ажиллав. https://www.facebook.com/groups/1873355006275950 | |
| | | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах; | -Мэдээллийг сар бүр шинэчлэх;<br>-Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбараар байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг сурталчлан холбогдох мэдээллийг байршуулав. Үүнд:<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ сар бүр (сарын мэдээ)<br>Албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ сар бүр (эхний 5 сарын мэдээ)<br>"Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх аян"-ны удирдамж Авлигатай тэмцэх газраас санаачлан гаргасан "ИРГЭН ТАНД" хуудасны мэдээлэл,<br>https://www.facebook.com/groups/1873355006275950<br>Авлигатай тэмцэх газрын Facebook хуудасны "ЭБАТ Мэдээлэл" хэсгээс цаг үеийн болон сургалт, зохион байгуулалтын бусад арга хэмжээний мэдээллийг тухай бүр авч ажиллав. | 100 |
| | | 1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх. | -2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх;<br>-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;<br>Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх. | Хот байгуулалт, хөгжлийн газрын хамт олон "Зөв зөвд Шударга зөв" соён гэгээрүүлэх аян, "Анзаар" аян, "Мэдье, Нэгдье аян", "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аян"-д байгууллага хамт олон нэгдэж, сургалтаар танилцуулсан мэдээлэл, зурагт хуудас зэргийг газрын www.uda.ub.gov.mn цахим хуудас, FB пэйж хуудас, нутгийн захиргааны байгууллагуудын ERP нэгдсэн удирдлагын системээр дамжуулан түгээж ажиллав.<br><br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3613986095546157<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3604272443184189/<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3604319146512852/<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3603511389926961/<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3603499923261441/ | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 2 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамруулах | 2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх; | -Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Газрын даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр шинээр томилогдсон 8 албан хаагчид, 07 дугаар сарын 21-ний өдөр шинээр томилогдсон 4 албан хаагчид, 08 дугаар сарын 29-ний өдөр 6 албан хаагчид, 11 дүгээр сарын 03-ны өдөр 4 албан хаагчид тус тус ажлын байранд дадлагажуулах чиглэлээр сургалт зохион байгуулав.<br><br>Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал", "Авлига, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ, түүний хор хөнөөл, урьдчилан сэргийлэх арга", "Ашиг сонирхлын зөрчил, мэдэгдэл, тайлбар гаргахад анхаарах асуудал", "Авлигын гэмт хэрэг"-ийн хуульчлагдсан байдал" сэдэвт 5 удаагийн сургалтад (танхимаар 2, цахимаар 3) 57 албан хаагч хамрагдсан. | 100 |
| | | 2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах | -Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх;<br><br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Ebarilga.ub.gov.mn геопортол, гар утасны аппликэйшн шинээр ашиглалтад оруулан авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулж 8 төрлийн 36 үйлчилгээг цахимаар хүн, хуулийн этгээдээс хүлээн авч байна. Хүн, хуулийн этгээд өөрийн илгээсэн хүсэлтийн явц, шийдвэрлэлтийг хянах боломжгой.<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн "Журам, жагсаалт, загвар батлах тухай" 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт" 14 үйлчилгээг (дугаар 223-236) нийт 15 үйлчилгээг И-Монголиа академи УТҮГ-тай хамтран Төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбох хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэв.<br><br>1.Нийтийн эдэлбэрийн газрыг хүн, хуулийн этгээдийн хөрөнгөөр тохижуулах, ашиглах, хамгаалах хүсэлтийг шийдвэрлэх<br>2.Нийтийн эдэлбэр газарт авто зогсоол төлөвлөх, байгуулах хүсэлтийг шийдвэрлэх<br>3.Барилга, байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх хүсэлт<br>4.Гадна зар сурталчилгааны байгууламжийн загвар зураг батлах<br>5.Барилгын ажил эхлүүлэх-Шинээр олгох<br>6.Барилгын ажил эхлүүлэх-Сунгах<br>7.Барилгын ажил эхлүүлэх-Нэмэлт өөрчлөлт оруулах (салгаж оруулсан)<br>8.Барилгын ажил эхлүүлэх-Буулгах зөвшөөрөл<br>9.Барилгын ажил эхлүүлэх-Цахилгааны ажлын зөвшөөрөл | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээг зохион байгуулах. | | 10.Барилгын ажил эхлүүлэх-Инженерийн шугам сүлжээний<br>11.Инженерийн бэлтгэл арга хэмжээ үерийн далан суваг, хөрсний усны трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ<br>12.Мэдээлэл холбооны шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ<br>13.Дулаан хангамжийн шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ<br>14.Цахилгаан хангамжийн шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ<br>15.Усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ<br><br>Тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| 3 | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; | -Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх;<br>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх;<br>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах;<br>-Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Хот байгуулалтын дотоод үйл ажиллагаатай холбоотой (10/04/2023/03 дугаар Худалдах, худалдан авах гэрээ, 10/04/2023/001 дугаар Амины орон сууцны хотхон захиалгаар барьж, ашиглалтад оруулах гэрээ, 10/04/202306 дугаар Бодит хурдны интернэт үйлчилгээ үзүүлэх гэрээ, 10/04/202307 дугаар Программ хангамжийн үйлчилгээ үзүүлэх гэрээ, 10/04/202308 дугаар Программ хангамж нийлүүлэх гэрээ, 10/04/2023/09 дугаар Эмнэлгийн багц шинжилгээ хийлгэх гэрээ,10/04/2023/10 дугаар Авто машинаар үйлчлэх гэрээ, 10/04/2023/13 дугаар Засгийн газрын худалдан авах ажиллагааны А3 сургалтын гэрээ, 10/04/2023/14 дугаар Худалдах, худалдан авах гэрээ) 9 гэрээнд дараах 3 заалтыг тусган ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг хувийг хэрэгт хавсаргасан.<br>1. "энэхүү гэрээтэй холбоотой ажил гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй" гэж.<br>2. "гэрээний үүрэг биелээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал нь барагдуулна" гэж хаалтын гэрээний Хариуцлага бүлэгт,<br>3. "захиалагч тал нь гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд гүйцэтгэгч талын хийсэн ажлын төлбөрийг бүрэн төлөх үүрэгтэй бөгөөд ажлын гүйцэтгэл 50 хувиас дээш гарсан тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхгүй болно" гэж гэрээний "Захиалагч тал" бүлэгт. | 100 |
| | | 3.2."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг | -Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх;<br>-Сургалт, мэдээлэл авсан байх; | Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Газрын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, газрын үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх | -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх. | ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод нээлттэй байршуулсан эсэхэд хяналт шалгалт хийх №Т2023/01 дугаар удирдамжийг Газрын даргаар батлуулж хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэв.<br>Мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөрийн талаарх мэдээллийг веб хуудсанд байршуулаагүй мөн газраас үзүүлж буй үйлчилгээг шийдвэрлэх журам, хугацааны талаарх мэдээллийг веб хуудсанд байршуулаагүй байв. Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2- оос 8.4.28 дахь заалт, 8.6.2.-оос 8.6.22 дахь хэсэгт заасан мэдээллийг газрын веб хуудсанд дутуу байршуулсан байсан бөгөөд Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган дутуу мэдээллийг гүйцээж оруулахыг холбогдох нэгжүүдэд анхааруулж зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллав.<br><br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газар дахь хяналтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дугаар захирамжийн танилцуулгыг нийт албан хаагдад, хуулиар хориглосон хэм хэмжээг зөрчиж хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх авлигын зөрчил гаргахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Барилга, байгууламжийн Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зураг, Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олголттой холбоотой асуудлаар хүн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийсэн хяналт шалгалт, цаашид дагаж мөрдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зөвлөмжийн танилцуулга", 2023 оны хагас жилийн дотоод хяналт шалгалтын ажлын тайланг 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Захиргааны зөвлөлийн 08 дугаар хуралд танилцуулж, төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүдэд тус тус сургалт зохион байгуулж ажиллав.<br><br>Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", Нийслэлийн Засаг даргын | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | 2023 оны А/727 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам", газрын Дотоод хяналт шалгалтын ажлын 2023 оны төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд төлөвлөгөөт 7 хяналт шалгалтын ажлыг газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэн судалгаа гаргаж дүгнэлт, зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх ажлын санал гаргаж ажиллав. Үүнд:<br>- Мэргэжлийн зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу үүссэн барилгын хувийн хэргийн бүрдэлд хийх хяналт, шалгалт,<br>- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын гэрээний хэрэгжилт, явц,<br>- Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг нээлттэй байршуулсан эсэх<br>- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан газрын төсөв, санхүүгийн мэдээллийг байршуулсан байдал<br>- Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний бүрдүүлбэр, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд удирдамж гарган газрын даргаар батлуулан төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх ажлын санал гаргаж ажиллав.<br>- Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаанд хийх дотоод хяналт шалгалтын ажлын №т2023/06 дугаар удирдамж, Шүүхээр хянан хэлэлцэгдэж тус газраас хариуцагчаар татагдсан Маргаанд дүн шинжилгээ хийх дотоод хяналт шалгалтын №Т2023/07 дугаар удирдамж газрын даргаар батлуулан хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэн зөвлөмж гаргаж ажиллав.<br>- Төлөвлөгөөт бус шалгалтын ажлын хүрээнд Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын явц, график төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр очиж шалгах удирдамж батлуулан шалгаж дүгнэлт, зөвлөмж, гаргаж ажиллав. Гарсан дүгнэлтийг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст тайлагнав.<br><br>Хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн ажил үйлчилгээ, мэргэжил ур чадварын талаар гаргасан 122 өргөдөл, гомдлыг хууль, дүрэм, журам, барилгын норм дүрэм хангасан эсэх шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж хариу өгч шийдвэрлэв. | |
| 4 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах | 4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх | -Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; | Ebarilga.ub.gov.mn геопортол, гар утасны аппликэйшн шинээр ашиглалтад оруулан хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдол, санал хүсэлтээ гар утаснаасаа өгч, хариуцсан алба хэлтэс, мэргэжилтэнд шууд хуваарилагдаж байгаа ба удирдлагын системээр шат дамжлага, хийгдэх ажлууд тодорхой болгож, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээ авах | (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м) | -Тайланд нотломжийг хавсаргасан байх ; | хийж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | |
| | | 4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх; | -2-оос доошгүй зохион байгуулсан байх;<br>-Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх | 1.Авлигатай тэмцэх газраас 05 дугаар сарын 03-ны өдөр “Авто замын салбар дахь асуудал, шийдэл, явган замын хавтан, авто замын хашлагийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт” сэдэвт хэлэлцүүлэгт Хот байгуулалтын инженерийн бэлтгэл, хяналтын хэлтсийн дарга оролцов. Авлигатай тэмцэх газрын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/8550 дугаар ирүүлсэн хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг зөвлөмжид заасан хугацаанд буюу 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/01/2036 дугаар албан бичгээр тайлагнаж ажиллав.<br><br>2.Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Авлигатай тэмцэх газартай хамтран “Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдэл, албан хаагчийн ёс зүйн зөрчил, авлига гарч болох нөхцөлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар” 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан уулзалтад Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга оролцов. Уулзалтаар хэлэлцсэн асуудлын хүрээнд гарсан санал, дүгнэлтийг үндэслэн “ИРГЭН ТАНД” хуудсыг үйлчилгээнд нэвтрүүлсэн. “ИРГЭН ТАНД” үлдэх хуудсанд хүсэлтийг хүлээн авсан үйлчилгээний ажилтны нэр, хүлээн авсан огноо, цаг, хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, шийдвэрлэлтийн явцыг хянах боломжтой www.uda.ub.gov.mn систем, гар утасны eBarilga аппликэйшн мэдээлэл, байгууллагын үйлчилгээний мэдээлэл агуулсан цахим хуудас Авлигатай тэмцэх газрын QR код зэргийг агуулсан болно. Авлигатай тэмцэх газраас гаргасан “ИРГЭН ТАНД” хуудасны талаарх шторкийг байгууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулан ил тод байдлыг нэмэгдүүлэн ажиллав. www.facebook.com/reel/636282528542096<br><br>3.Авлигатай тэмцэх газраас 2023 оны 06 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулсан "Барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг үнэлэх ба хүчитгэх, олон улсын | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | туршлага" Олон Улсын техникийн семинар, "Барилгын салбарын ил тод байдал, Авлигаас сэргийлэх нь, олон улсын туршлага" дугуй ширээний ярилцлагад Барилга, байгууламжийн чанарын хэлтсийн дарга, Барилгын чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн нар оролцов.<br><br>4.Авлигатай тэмцэх газраас 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан Барилгын салбарт хэрэгжиж буй цахим системийг уялдуулах уулзалт"-ад Газрын дарга, Хот байгуулалтын мэдээллийн хэлтсийн дарга оролцож, “eBarilga Хот байгуулалтын цахим систем”-ийн танилцуулгыг хийж санал солилцов.<br><br>5.Барилгын салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сайжруулах ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамнаас “Барилгын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ болон тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах” ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг “Монголын барилгын инженерүүдийн холбоо” төрийн бус байгууллагатай гэрээлэн гүйцэтгүүлж байгаа ажлын хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр “Монголын барилгын инженерүүдийн холбоо” төрийн бус байгууллагын төлөөлөлтэй одоо хэрэгжиж байгаа Барилгын тухай хуулийн үзэл баримтлал, нэр томьёо, зүйл заалтын хувьд зөрчил байгаа эсэх нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагын талаар эрхэлж буй үйл ажиллагааных нь хүрээнд асуумж авч, уулзалт хийж санал солилцлоо.<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3589183661359734 | |
| | | 4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах. | -Бодитой үр дүнг тооцсон байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх | Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг 117 иргэнээс шийдвэрлэлтийн шуурхай байдал, хүнд суртал, авлига шаардсан эсэх, албан хаагчийн ёс зүй, ур чадвар, сэтгэл ханамжийн үнэлгээ зэрэг асуудлаар авлаа. Нийт судалгаанд оролцогчдын 97 хувь нь зэрэг (сайн) гэсэн үнэлгээ өгсөн байна.<br>2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн Ebarilga удирдлагын системийн цахим бүртгэлээр үйлчилгээ авч байгаа хүн, хуулийн этгээдэд шийдвэрлэх хугацааг тодорхойлж бичсэн 3800 орчим “Иргэн танд” хуудсыг өгч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг ханган ажиллаж байна.<br>Үйлчилгээний бүртгэл хяналтын хуудасны дагуу 6449 материалыг шалгаж, Ebarilga удирдлагын системийн цахим системд бүртгэн ажиллав. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 5 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдад танилцуулах; | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Авлигатай тэмцэх газрын 2023 оны 01/10701 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 03/4060 дугаар албан бичиг, “Мэдье, нэгдье аян”-нд нэгдэх тухай 03/6168 дугаар албан бичгээр авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар ирүүлсэн зөвлөмж, удирдамжийг Захиргааны зөвлөлийн 2 удаагийн хурлаар танилцуулж, нийт албан хаагчдад үүрэг, чиглэл өгч ажилласан байна.<br><br>Авлигатай тэмцэх газраас санаачилсан “Авлигыг мэдээл 110" - “Зөв зөвд Шударга зөв” соён гэгээрүүлэх аян, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж буй мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хор уршиг, үр дагаврын талаар мэдлэг олгох, хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий “АНЗААР” 14 хоногийн аян, Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 384 жилийн ойг угтан Монгол Улсын Засгийн газраас Авлигатай тэмцэх жилийн хүрээнд хэрэгжүүлж буй “5 Ш ажиллагаа”, Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг дэмжих, албан хаагчдын ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг, харилцаа. хандлагыг нэмэгдүүлэх зорилго бүхий “Мэдье, нэгдье” 1 сарын аян нийслэлээс зохион байгуулсан үйл ажиллагааг дэмжиж, оролцсон.<br><br>Авлигатай тэмцэх газрын 2023 оны “Төлөвлөгөөнд санал авах тухай” 08/14559 дугаар албан бичиг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03/5849 дугаар албан бичгийн дагуу Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгуулах 1 арга хэмжээний санал хүргүүлэв. | 100 |
| | | 5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал; | -Санал тусгасан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг шинээр баталсантай холбоотой Газрын даргын 2023 оны А/34 дүгээр тушаалаар газрын Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулав.<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн Газрын Төрийн албан хаагчийн Ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж, дүрмийн төслийг Авлигатай тэмцэх газарт 2023 оны 12 дугаар сарын 00-ны өдрийн 01/10/0000 дугаар албан бичгээр, Ёс зүйн дэд хороо байгуулсан шийдвэр болон дүрмийн төслийг zoljargal@iaac.mn цахим шуудангаар тус тус хүргүүлсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | 5.3.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулах | -Төлөвлөгөөг батална, олон нийт танилцах боломжоор хангасан байх;<br>-khutulbur.iaac.mn (Авлигын эсрэг Үндэсний хөтөлбөр) цахим санд нэмж оруулсан байх,<br>-Тайлагнасан байх. | Хот байгуулалт, хөгжлийн газрын хамт олон "Зөв зөвд Шударга зөв" соён гэгээрүүлэх аян, "Анзаар" аян, "Мэдье, Нэгдье аян", "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аян"-д байгууллага хамт олон нэгдэж, сургалтаар танилцуулсан мэдээлэл, зурагт хуудас зэргийг газрын www.uda.ub.gov.mn цахим хуудас, FB пэйж хуудас, нутгийн захиргааны байгууллагуудын ERP нэгдсэн удирдлагын системээр дамжуулан түгээж ажиллав.<br><br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3613986095546157<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3604272443184189/<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3604319146512852/<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3603511389926961/<br>www.facebook.com/groups/1873355006275950/posts/3603499923261441/ | 100 |
| | | 5.3.1 Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэл, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавих (Жишээ нь: тушаал шийдвэр гаргахдаа үндэслэх хэсэгт хамааралгүй хууль, тогтоол, захирамжийг үндэслэн тушаал гардаг асуудлыг арилгахад чиглэсэн) | - Ажлын хэсэг байгуулсан, хэн нэгэн албан тушаалтанд даалгасан тушаалын хэрэгжилтэд үр дүнг тооцсон байх, | Газрын үндсэн үйл ажиллагаатай холбоотой гарсан А 38 тушаал, хүний нөөцийн чиглэлээр гарсан Б161 тушаалын төслийн хууль зүйн үндэслэлтэй эсэхэд Дотоод хяналт, хуулийн хэлтэс хяналт тавьж ажиллав.<br>Газрын даргын тушаалаар баталсан байнгын үйл ажиллагаатай ажилладаг 8 ажлын хэсгийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг хагас бүтэн жилээр тайлагнан ажиллав.<br>Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоол, Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Шил" ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 01 дүгээр албан даалгавар Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар, Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 67 дугаар тушаалын дагуу Газрын даргын 2023 оны А/17, 18 дугаар тушаалаар байгуулагдсан 2 ажлын хэсэг заасан хугацаанд холбогдох мэдээ, тайланг хүргүүлж ажиллав.<br>Газрын даргын 2023 оны А/01 дүгээр тушаалаар байгуулагдсан "Стандарт нэвтрүүлэх дэд ажлын хэсэг", "Үүрэг, чиглэл өгөх тухай" А/10 дугаар тушаал, "Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ажил хариуцуулах тухай" А/19 дүгээр тушаал, "Ажлын хэсэг байгуулах тухай" А/33, 35 дугаар тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын явц, үр дүнг Захиргаа, зөвлөлийн хурлаар тайлагнаж ажиллав. | 100 |
| | | 5.3.2 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргаж байгаа өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хугацаа | -Үр дүнг тооцсон байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх | Албан хаагчтай холбоотой 9 гомдол, 3 талархал хүлээн авсан, 1 хүсэлтийг хүлээн авч, байгууллагын Ёс зүйг дэд хороо болон нийт албан хаагчдад танилцуулж ажиллав.<br>o 2 иргэний гомдлыг татуулж,<br>o 3 иргэний гомдолд хариу тайлбарыг албан бичгээр хүргүүлж, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | хэтрүүлэхгүй байх, бодитой шийдвэрлэж хугацаанд нь зохих хариу өгөх ажлыг сайжруулах ажил зохион байгуулах. (Албан хаагчдын ёс зүйн зөрчил, дутагдал хамаарах) | | ○ 3 иргэний гомдолд албан хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй иргэнд хариу тайлбар өгч ажиллав.<br>○ Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 1 гомдол үүссэн нөхцөл байдлын талаар тайлбар өгсөн.<br>Авлигатай тэмцэх газраас 2023 оны “Гомдол шийдвэрлэх тухай” 03/9027 дугаар албан бичгээр ирүүлсэн 1 албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудлыг Ёс зүйн зөвлөлтэй хамтран шалгаж тухайн албан хаагчийн буруутай үйл ажиллагаа, ёс зүйн зөрчил тогтоогдоогүй тул хариуг 2023 оны 01/01/1433 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас дээрх гомдолтой холбоотой ирүүлсэн Зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллав.<br>Y:\2.Захиргаа санхүүгийн хэлтэс\2. BUYANJARGAL\Аян 2023<br>Талархлыг холбогдох нэгж, албан хаагчдад болон нийт албан хаагчдад танилцуулав.<br>Байгууллагын алба хаагчдад ёс зүйн зөрчлөөс ангид байх, цаашид сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх тал дээр цаг тухай бүрд зөвлөмж өгч ажилласан ба алба, хэлтсийн ахлах мэргэжилтнүүдэд цаг үеийн байдлаар мэдээлэл өгсөн. | |
| | | 5.3.3 Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, Засгийн газрын тогтоолоор хүчин төгөлдөр бус болсон эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх. | -Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох дүрэм, журмыг хяналтад авч, кодификаци хийсэн байх | Байгууллагын цахим хуудас дахь “Хууль, дүрэм журам” булан дахь хуулиуд, Улсын их хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, газрын даргын тушаалаар батлагдсан дүрэм журмын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эсэхэд хяналт тавьж тогтмол шинэчлэлтийг хийн ажиллаж байна. | 100 |
| | | 5.3.4 Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах. (Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх | -Төсөв, санхүүгийн зөрчилгүй ажиллах<br>-Сүүлийн 2 жилийн хугацаанд илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргаагүй байх | Батлагдсан төсвийг үр ашигтай төлөвлөн зарцуулж батлагдсан төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэл хийгдэж байна. Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг ханган цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.<br>• Жилийн эцсийн тооллогын тооцоо бодсон актыг үйлдэж, тооллогын үр дүнг хэлэлцэн шийдвэрлэж цаашид үндсэн хөрөнгийн бүртгэлийг батлагдсан маягт, стандартын дагуу | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | чиглэлээр ажил зохион байгуулах, Нийслэл, Үндэсний аудитын газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын шалгалтаар жил бүр илэрдэг санхүүгийн зөрчил, дутагдлыг цаашид гаргахгүй байхад чиглэсэн үр дүнтэй ажил зохион байгуулах) | | бүртгэх, тооллогыг үр дүнтэй хийх, тооллогын тооцоог үнэн зөв гаргах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>• Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл заалтыг мөрдлөг болгон ашиглах хугацаа дууссан, дахин ашиглах боломжгүй үндсэн хөрөнгүүдийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт акталж, устгах саналыг хүргүүлсэн.<br>• Урьдчилж гарсан зардлыг холбогдох байгууллагуудтай тооцоо нийлэн баталгаажуулж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан.<br>• Нийслэлийн төрийн сан дахь НТАГ хүү торгуулийн 100200000908 тоот дансанд төвлөрүүлсэн.<br>• Худалдан авалтад анхан шатны баримтыг стандартын дагуу бүрдүүлж, төлбөрийн баримтыг цахим системд бүртгүүлэн цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл заалтыг мөрдлөг болгон цалингийн зардлаас бусад 5 саяас дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр хүлээн авагчийн нэр, гүйлгээний агуулга, санхүүжилтийн хэмжээ, худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр зэрэг заалтуудыг хэрэгжүүлэн стандартын дагуу хуулийн хугацаанд мэдээлэн цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавин ажиллаж байна.<br>Газрын 2023 оны Дотоод хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөнд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Газрын төсөв, санхүүгийн мэдээллийг байршуулсан байдалд хяналт шалгалт хийх ажлыг тусгасан. Мөн Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Аудитын газар, Дотоод аудитын алба зэрэг хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хийгдсэн -хяналт • шалгалтын ажлын дүгнэлт, зөвлөмжийн хариу арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллав. | |

ТАНИЛЦСАН: ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ХАН-УУЛ

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.БАДАМХАНД

ТАЙЛАН ГАРГАСАН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Т.БУЯНЖАРГАЛ